



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/067/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхбаатар

Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn

Аудитор: Г.Мөнхчимэг

Утас: 261885 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг

Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.05 № 07/1178
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Сэргээн босголт, Зээлийн Банкнаас хийсэн үнэлгээний багийн хяналтаар хуваарилалтын дагуу олгогдоогүй 291,375.0 мянган төгрөгийн 45 ширхэг зөөврийн компьютер байгааг илрүүлж, Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд асуудал шийдвэрлүүлэх тухай албан тоотыг хүргүүлсэн боловч хариу өгөөгүй байна.
- Тайлант онд нийт 34,472.8 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулаагүй, жолоочийн тооцооны хуудсаар тайлагнасан баримтыг үндэслэн тооцоог хянаагүй зардалд тайлагнасан.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын хавсралт "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.3.1 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд "Үнэн ба зөв байх", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сэргээн босголт, Зээлийн Банкнаас хийсэн мониторингийн үнэлгээний хурлын тэмдэглэлд "Төсөл хэрэгжилтийн явц удаашралтай байсныг тэмдэглэсэн бөгөөд энэ нь цаг үрсэн, хүнд суртал бүхий дүрэм журам, зөвшөөрөл авах ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн хоорондын харилцаа хязгаарлагдмал, түүнчлэн богино хугацаанд огцом гаргасан өөрчлөлт зэргээс шалтгаалжээ" гээд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зүгээс төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг яаралтай авахыг хүссэн байна. Төслөөр 27,500.0 мянган еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгө зарцуулахаас 2024 оны эцсийн байдлаар 10,702.3 мянган евро зарцуулж 38.9 хувийн зарцуулалттай байна. Үүний 26.1 хувийг зөвлөх багийн зардал, 13.7 хувийг сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгааны зардлууд, мөн төсөл хэрэгжүүлэх нэгжийн монгол улсаас санхүүждэг урсгал зардлыг нэмж тооцвол төслийн бодит үр дүн хангалтгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

ЮНЕСКО-ийн Дэлхийн Өв болон Шим мандлын нөөц газарт бүртгүүлэхээр тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн өвөрмөц байгалийн үзэсгэлэнгээр дэлхийд гайхагдах Монголын их говь буюу түүнд багтах Говийн бага дархан цаазат газрын А болон Б хэсэг, Говийн их дархан цаазат газрын А болон Б хэсэг, нэмэлтээр Ээж Хайрхан уулын байгалийн дурсгалт газар, Алаг Хайрхан байгалийн нөөцийн газар нутгуудын хосгүй үнэ цэнийг харуулсан цуврал нэвтрүүлгийг бэлтгэж байна.

Бусад асуудал

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 27,500.0 мянган еврогийн санхүүгийн дэмжлэгээс Германы Засгийн Газраас буцалтгүй тусламж хэлбэрээр үзүүлэх, 4,700.0 мянган еврог Монгол Улсын Засгийн Газраас санхүүжүүлэхээр гэрээгээр тохирсон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,008,136,288.59	1,287,042,225.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,005,033,808.59	1,282,596,155.77
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	4,005,033,808.59	1,282,596,155.77
31220	Гадаад валют	4,005,033,808.59	1,282,596,155.77
31223	Арилжааны банк дахь харилцах	4,005,033,808.59	1,282,596,155.77
33	АВЛАГА	-	2,642,700.17
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	723,413.79
33500	Бусад авлага	-	1,919,286.38
33510	Байгууллагаас авах авлага	-	1,919,286.38
35	БАРАА МАТЕРИАЛ	3,102,480.00	1,803,370.00
35400	Хангамжийн материал	3,102,480.00	1,803,370.00
35410	Бичиг хэргийн материал	3,102,480.00	1,129,800.00
35470	Бусад хангамжийн материал	-	673,570.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	169,996,604.26	147,445,793.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	169,996,604.26	147,445,793.36
39200	Биет хөрөнгө	169,996,604.26	147,445,793.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	277,025,000.00	277,025,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(169,699,478.40)	(195,256,497.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,480,490.00	129,110,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,143,795.60)	(70,961,538.98)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,853,863.26	64,853,863.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(54,519,475.00)	(57,325,523.80)
39300	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	7,447,500.00	7,447,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,447,500.00)	(7,447,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,178,132,892.85	1,434,488,019.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	42,751,321.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	42,751,321.66
41300	Өглөг	-	42,751,321.66
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	17,999.53
41360	Бусад өглөг	-	42,733,322.13
41361	Байгууллагад төлөх өглөг	-	24,244,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	18,489,322.13
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,178,132,892.85	1,391,736,697.64
51	Засгийн газрын хувь оролцоо	4,178,132,892.85	1,391,736,697.64
51200	Хуримтлагдсан үр дүн	4,178,132,892.85	1,391,736,697.64
51210	Өмнөх үеийн үр дүн	2,793,214,454.40	4,178,132,892.85
51220	Тайлант үеийн үр дүн	1,384,918,438.45	(2,786,396,195.21)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,178,132,892.85	1,434,488,019.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	13,561,951,509.45	14,480,991,449.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,704,113,509.45	13,382,353,361.67
120	Нийтлэг татварын бус орлого	583,553,947.64	525,050,617.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	583,553,947.64	525,050,617.28
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	583,553,947.64	525,050,617.28
122	Тусламжийн орлого	12,120,559,561.81	12,857,302,744.39
122002	Хандив тусламж /гадаад/	12,120,559,561.81	12,857,302,744.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,838,000.00	1,098,638,088.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	857,838,000.00	1,097,500,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	857,838,000.00	1,097,500,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	1,138,088.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,330,068,560.49	5,845,887,971.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,330,068,560.49	5,845,887,971.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,694,627,390.41	5,133,156,470.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,514,122.16	594,005,411.24
210101	Үндсэн цалин	476,514,122.16	594,005,411.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,422,865.28	69,187,722.95
210202	Тэтгэмжийн даатгал	59,564,265.28	69,187,722.95
210205	Эрүүл мэндийн даатгал	1,858,600.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,296,052.00	118,771,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,517,752.00	-
210302	Түлш, халаалт	2,059,800.00	-
210304	Байрны түрээс	109,718,500.00	118,771,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,289,600.00	49,767,019.82
210401	Бичиг хэрэг	8,011,200.00	7,659,680.00
210402	Тээвэр, шатахуун	10,600,000.00	13,718,801.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,535,000.00	7,353,848.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,143,400.00	21,034,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,730,000.00	10,061,800.00
210604	Урсгал засвар	12,730,000.00	10,061,800.00
2107	Томилолт, зочны зардал	48,762,750.00	57,439,950.00
210702	Дотоод албан томилолт	48,762,750.00	56,889,950.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,902,126,847.34	4,188,741,716.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,869,481,730.11	4,183,782,668.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,998,840.00	4,785,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,646,277.23	174,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,485,153.63	45,181,450.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,301,400.00	3,000,640.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,183,753.63	42,180,810.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	635,441,170.08	712,731,500.76
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	583,553,947.64	525,050,617.28
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	583,553,947.64	525,050,617.28
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,887,222.44	187,680,883.48
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,231,882,948.96	8,635,103,477.92
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	801,318,029.10	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	801,318,029.10	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,648,282,539.61	11,421,499,673.13

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

225004	Гадаад валютын ханшийн зерүүний гарз	480,969,648.00	234,500,624.49
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	5,167,312,891.61	11,186,999,048.64
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,384,918,438.45	(2,786,396,195.21)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,811,084,670.20	3,860,646,866.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,953,246,670.20	2,763,146,866.31
120	Нийтлэг татварын бус орлого	-	567,700.00
120009	Бусад орлого	-	567,700.00
122	Тусламжийн орлого	6,953,246,670.20	2,762,579,166.31
122002	Хандив тусламж /гадаад/	6,953,246,670.20	2,762,579,166.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	857,838,000.00	1,097,500,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	857,838,000.00	1,097,500,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	857,838,000.00	1,097,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,150,647,878.67	1,406,992,836.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,150,647,878.67	1,406,992,836.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,098,760,656.23	1,219,311,952.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,768,075.27	568,610,843.24
210101	Үндсэн цалин	463,768,075.27	568,610,843.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,296,208.00	68,500,443.08
210201	Тэтгэврийн даатгал	46,859,008.00	44,672,486.14
210202	Тэтгэмжийн даатгал	5,609,300.00	6,033,099.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,487,400.00	3,057,747.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,900.00	2,891,468.60
210205	Эрүүл мэндийн даатгал	11,218,600.00	11,845,641.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,296,052.00	118,771,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,517,752.00	-
210302	Түлш, халаалт	2,059,800.00	-
210304	Байрны түрээс	109,718,500.00	118,771,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,289,600.00	33,851,748.20
210401	Бичиг хэрэг	7,241,200.00	6,998,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,600,000.00	14,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,535,000.00	7,353,848.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,913,400.00	4,999,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,730,000.00	10,389,800.00
210604	Урсгал засвар	12,730,000.00	10,389,800.00
2107	Томилолт, зочны зардал	48,762,750.00	58,147,650.00
210702	Дотоод албан томилолт	48,762,750.00	57,297,650.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,352,316,570.96	358,040,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,319,671,453.73	353,081,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,998,840.00	4,785,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	17,646,277.23	174,048.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,301,400.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,301,400.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,887,222.44	187,680,883.48
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,887,222.44	187,680,883.48

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,887,222.44	187,680,883.48
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,660,436,791.53	2,453,654,030.31
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,552,749,601.38	4,941,591,058.64
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,552,749,601.38	4,941,591,058.64
2200	Дотоод эх үүсвэрээр	4,552,749,601.38	4,941,591,058.64
222001	Тоног төхөөрөмж	4,552,749,601.38	4,921,961,058.64
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	19,630,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,552,749,601.38)	(4,941,591,058.64)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	153,180,605.06	(234,500,624.49)
14	Бусад эх үүсвэр	320,348,386.93	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	320,348,386.93	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	167,167,781.87	234,500,624.49
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	167,167,781.87	234,500,624.49
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,260,867,795.21	(2,722,437,652.82)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,744,166,013.38	4,005,033,808.59
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,005,033,808.59	1,282,596,155.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,958,523,599.95	2,958,523,599.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(165,309,145.55)	(165,309,145.55)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,793,214,454.40	2,793,214,454.40
4	Тайлант үеийн үр дүн	-	1,384,918,438.45	1,384,918,438.45
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	4,178,132,892.85	4,178,132,892.85
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	4,178,132,892.85	4,178,132,892.85
8	Тайлант үеийн үр дүн	-	(2,786,396,195.21)	(2,786,396,195.21)
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,391,736,697.64	1,391,736,697.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,575,160,000.00	14,186,626,756.82	(9,388,533,243.18)	60.2
УРСГАЛ ЗАРДАЛ	3,097,500,000.00	2,909,819,116.52	(187,680,883.48)	93.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,097,500,000.00	2,909,819,116.52	(187,680,883.48)	93.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,000,000.00	568,610,843.24	(111,389,156.76)	83.6
Үндсэн цалин	680,000,000.00	568,610,843.24	(111,389,156.76)	83.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,000,000.00	68,500,443.08	(16,499,556.92)	80.6
Тэтгэврийн даатгал	57,800,000.00	44,672,486.14	(13,127,513.86)	77.3
Тэтгэмжийн даатгал	6,800,000.00	6,033,099.45	(766,900.55)	88.7
ҮОМШӨ-ний даатгал	3,400,000.00	3,057,747.89	(342,252.11)	89.9
Ажилгүйдлийн даатгал	3,400,000.00	2,891,468.60	(508,531.40)	85.0
Эрүүл мэндийн даатгал	13,600,000.00	11,845,641.00	(1,754,359.00)	87.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,500,000.00	118,771,400.00	(4,728,600.00)	96.2
Байрны түрээс	123,500,000.00	118,771,400.00	(4,728,600.00)	96.2
Хангамж, бараа материалын зардал	36,575,000.00	33,851,748.20	(2,723,251.80)	92.5
Бичиг хэрэг	7,000,000.00	6,998,000.00	(2,000.00)	99.9
Тээвэр, шатахуун	15,000,000.00	14,500,000.00	(500,000.00)	96.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,575,000.00	7,353,848.20	(2,221,151.80)	76.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,999,900.00	(100.00)	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	13,360,000.00	10,389,800.00	(2,970,200.00)	77.8
Урсгал засвар	13,360,000.00	10,389,800.00	(2,970,200.00)	77.8
Томилолт, зочны зардал	93,000,000.00	57,739,950.00	(35,260,050.00)	62.1
Гадаад албан томилолт	15,000,000.00	-	(15,000,000.00)	-
Дотоод албан томилолт	66,000,000.00	56,889,950.00	(9,110,050.00)	86.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	12,000,000.00	850,000.00	(11,150,000.00)	7.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,063,065,000.00	2,048,954,932.00	(14,110,068.00)	99.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,058,100,000.00	2,043,995,884.00	(14,104,116.00)	99.3
Даатгалын үйлчилгээ	4,785,000.00	4,785,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	174,048.00	(5,952.00)	96.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,477,660,000.00	11,276,807,640.30	(9,200,852,359.70)	55.1
Тоног төхөөрөмж	20,477,660,000.00	11,276,807,640.30	(9,200,852,359.70)	55.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,575,160,000.00	11,698,689,728.49	(11,876,470,271.51)	49.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,097,500,000.00	909,819,116.52	(187,680,883.48)	82.9
Улсын төсвөөс санхүүжих	1,097,500,000.00	909,819,116.52	(187,680,883.48)	82.9
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	22,477,660,000.00	10,788,870,611.97	(11,688,789,388.03)	48.0
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	22,477,660,000.00	10,788,870,611.97	(11,688,789,388.03)	48.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	14	11	3	78.6
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	10	3	76.9
Үйлчлэх ажилтан	-	-	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 10,613,026.7 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад 8,237,814.2 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 2,375,212.5 мянган төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төслийн санхүүжүүлэгчээс 500.0 мянган еврогоос дээших гэрээний төлбөрийг харилцагчийн дансанд шууд шилжүүлдэгтэй холбоотой Мөнххада ХХК-д 935.0 мянган евро, Майнс Ап ХХК-д 792.0 мянган евро, зөвлөх багийн үйл ажиллагааны төлбөр 475.9 мянган евро нийт 2,202.9 мянган евро буюу 8,025,889.3 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн дансанд тусгаагүй	1	8,025,889.3	1	8,025,889.3	-	-	1	8,025,889.3	-	-
2024 оны 08 сарын 08-ны өдрийн 68.0 мянган еврогийн гүйлгээ төрийн банканд 67.9 мянган евро орж 55 еврогийн шимтгэл, 2024 оны 11 сарын 29-ний өдрийн 695.2 мянган еврогийн гүйлгээ 2024 оны 12 сарын 02-ний өдөр 695.1 мянган евро орж 55 еврогийн гүйлгээний шимтгэлийн зарлагыг санхүүгийн тайланд тусгаагүй	1	-	1	-	-	-	1	-	-	-
Санхүүжилтээс татан төвлөрүүлсэн 187,680.9 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан, тохируулах бичилт хийгээгүй.	1	187,680.9	-	-	1	187,680.9	1	187,680.9	-	-
Дүйнхэр тэргүүн ХХК-ийн гэрээт ажлын төлбөр 24,244.0 мянган төгрөгийг өр төлбөр бүртгэж, аккруэл сууриар бүртгээгүй	1	24,244.0	-	-	1	24,244.0	1	24,244.0	-	-
Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн дансыг арилжааны банканд 5 аймагт нээж 2,375,212.5 мянган төгрөгийг байршуулж, малчид, иргэдийн амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх,	1	2,375,212.5	-	-	-	-	-	-	1	2,375,212.5

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Биологийн олон янз байдлын хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл 2024 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор 227 иргэнд зээлдүүлснээр зээлийн авлага 1,168,782.3 мянган төгрөг байна. 2024 оны хагас жилээс хойш зээл олгохыг зогсоосон боловч Сэргээн босголт, Зээлийн Банкнаас орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үзэл баримтлалыг баталж, завсрын үр дүнгийн үнэлгээ эерэг гарсан тохиолдолд тус зээлийг 2 дугаар үе шатанд хэрэгжүүлэх эсэх эцсийн шийдвэр гаргахаар тэмдэглэсэн байна. Гэтэл уг зээлийн хөрөнгийн бүртгэл төслийн санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.										
Дүн	5	10,613,026.7	2	8,025,889.3	2	211,924.9	4	8,237,814.2	1	2,375,212.5

3.2 Аудитаар нийт 537,120.2 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 291,375.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 245,745.2 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сэргээн босголт, Зээлийн Банкнаас хийсэн үнэлгээний багийн хяналтаар хуваарилалтын дагуу олгогдоогүй 291,375.0 мянган төгрөгийн 45 ширхэг зөөврийн компьютер байгааг илрүүлж, Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд асуудал шийдвэрлүүлэх тухай албан тоотыг холбогдох бичиг баримтын хамт 2024.11.12-ны өдөр хүргүүлсэн боловч хариу өгөөгүй байна.	1	291,375.0	-	-	1	291,375.0	-	-
Тайлант онд нийт 34,472.8 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулаагүй, жолоочийн тооцооны хуудсаар тайлагнасан баримтыг үндэслэн тооцоог хянаагүй байна.	1	34,472.8	-	-	-	-	1	34,472.8
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 56 нэр төрлийн 175,082.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	175,082.6	-	-	-	-	1	175,082.6
Тайлант онд 36,189.8 мянган төгрөгийн томилолтын зардал гарсан байна. Томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, дараа тайлангийн тооцоо бодолт хангалтгүй байна.	1	36,189.8	-	-	-	-	1	36,189.8
Дүн	4	537,120.2	-	-	1	291,375.0	3	245,745.2

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 1,394,703.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,394,703.5 мянган төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэнд дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах тухай өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргаж цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 удаагийн 56,179.2 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож, 13 удаагийн 1,097,500.0 мянган төгрөгийн орлого, 6 удаагийн 241,024.3 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.	1	1,394,703.5	1	1,394,703.5	-	-
Дүн	1	1,394,703.5	1	1,394,703.5	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Сэргээн босголт, Зээлийн Банкнаас хийсэн мониторингийн үнэлгээний хурлын тэмдэглэлд "Төсөл хэрэгжилтийн явц удаашралтай байсныг тэмдэглэсэн бөгөөд энэ нь цаг үрсэн, хүнд суртал бүхий дүрэм журам, зөвшөөрөл авах ажиллагаа, төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн хоорондын харилцаа хязгаарлагдмал, түүнчлэн богино хугацаанд огцом гаргасан өөрчлөлт зэргээс шалтгаалжээ" гээд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны зүгээс төсөл хэрэгжүүлэх нэгж болон зөвлөх багийн хоорондын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээг яаралтай авахыг хүссэн байна. Төслөөр 27,500.0 мянган еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгө зарцуулахаас 2024 оны эцсийн байдлаар 10,702.3 мянган евро зарцуулж 38.9 хувийн зарцуулалттай байна. Үүний 26.1 хувийг зөвлөх багийн зардалд, 13.7 хувийг сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгааны зардлууд, мөн төсөл хэрэгжүүлэх нэгжийн монгол улсаас санхүүждэг урсгал зардлыг нэмж тооцвол төслийн бодит үр дүн хангалтгүй, үр ашиг багатай байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-
Нийт дүн	2	1,394,703.5	1	1,394,703.5	1	-

